



GreenerZ PopUp Festival

“Эдийн засгийн ногоон шилжилт” төсөл

Каритас Чех Републик ОУТББ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар нь 2006 оноос хойш Монгол улсын боловсрол, нийгэм, эрүүл мэнд, ногоон барилга болон хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа бөгөөд Бүгд найрамдах Чех улсын Праг хотод төвтэй, дэлхийн хэд хэдэн улс орнуудад салбартай төрийн бус, хүмүүнлэгийн байгууллага юм.

Каритас Чех Републик байгууллага нь Европын Холбооны СВИЧ-Эйшиа хөтөлбөрийн хүрээнд 2022-2025 оны хугацаанд “Эдийн Засгийн Ногоон Шилжилт” төслийг хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Монголын хүнс, ус, ундааны салбарын ЖДҮ, жижиглэн худалдаа эрхлэгч нарыг салбартаа тогтсон хэв загвараа илүү ногоон болгох, бизнэсийн үр ашгаа нэмэгдүүлэн өөрчлөхөд нь шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх, ногоон баталгаажуулалт, эко тэмдгийг зах зээлд нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Дэлхийн олон улс оронд байгальд орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэгчдээ дэмжин эко тэмдэг олгож, хэрэглэгчид нь ч түүнийгээ таньж хэрэглэх замаар байгаль орчин болон улсынхаа ирээдүйн хөгжлийг дэмждэг бөгөөд манай улсын хувьд төслийн баг үндэсний эко тэмдгийг олгох журмыг шинэчлэх баталж, эко тэмдгийн олгох схемийг боловсруулах Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай нягт хамтран ажиллаж байгаа билээ.

Энэхүү зорилгын хүрээнд олон нийтэд танилцуулах, эх орондоо байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл явуулж эко тэмдэг авахаар зорьж буй Үндэсний үйлдвэрлэгчдэдээ дэмжих, байгальд ээлтэй зөв дадал, эко сонголттой их хотын иргэдийг бий болгох зорилгоор 2025 оны 5 сарын 24-ний Бямба гаригт 11 – 17 цагийн хооронд “GreenerZ PopUp Festival” - г зохион байгуулахаар ажиллаж байна. Энэхүү залуучуудад чиглэсэн арга хэмжээ нь Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр дэх Улсын Драммын Эрдмийн Театрын урд байрлах Ю.Цэдэнбалын цэцэрлэгт зохион байгуулагдах бөгөөд мөн энэ үеэр

ногоон үзэл санааг дэмжигчид болон оролцогчдын парад хийхээр төлөвлөж байгаа бэлтгэл ажлуудаа эхлээд байна.

Хавсралт 1: Арга хэмжээний хөтөлбөр

GreenerZ FESTIVAL

Ногоон үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг дэмжих “ЭКО бол гоёл биш СОЁЛ” уриатай бүх нийтийн баяр

Хугацаа: 2025 оны 5-р сарын 24-ний Бямба гараг 11:00~17:00

Газар: Улсын Драммын Эрдмийн Театрын урд Ю.Цэдэнбалын цэцэрлэг

Үзэсгэлэнгийн асруудын тоо: 3m x 3m хэмжээтэй эко хэрэглээний мэдлэг олгох асар – 6 , тайз -1 , Үндэсний үйлдвэрлэгчдийн байгальд ээлтэй үйл ажиллагаагаа таниулах, эко хэрэглээг дэмжих асар – 10

Зорилго: Европын Холбооны Свич Эйшиа хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “**Эдийн засгийн ногоон шилжилт**” төслийн үр дүнг олон нийтэд таниулах, үндэсний эко тэмдэгийн талаар ойлголт мэдлэг олгох, энэ тэмдэгийг авахаар ажиллаж буй үндэсний үйлдвэрүүдийг олон нийтэд сурталчлан таниулах замаар ирээдүйн хариуцлагатай, ногоон үзэл санаа бүхий хэрэглэгчдийг бэлдэнэ.

Энэхүү арга хэмжээнд оролцсон компаниудын хувьд төслийн хүрээнд үйлдвэрлэлийн явцад гарсан дэвшил, өөрчлөлт, хөрөнгө оруулалтынхаа үр дүнг хэрэглэгчид олон нийтэд таниулах, ногоон үзэл санааг дэмждэг, эко худалдан авалт хийдэг хэрэглэгч болоход ялангуяа залуу хойч үеийг уриалах, энэ үйлсэд татан оролцуулах.

Үүнд:

- **Тайзны энтертайнмент үйл ажиллагаа:** Тайзны хэсэгт өдөрлөгийн нээлт, оролцогч үйлдвэрлэгчдийн танилцуулга, хөгжөөнт тоглоом, урлагийн үзүүлбэр, шагнал гардуулах ёслол болно.
- **Иргэдэд мэдлэг мэдээлэл олгох хэсэгт:** Бүртгэл мэдээлэл, хэрэглэгчийн өөрийнхөө худалдан авалтын зан үйлийг тодорхойлох сорилууд, ногоон худалдан авалт, тойрог эдийн засгийн, дэлхий дахинд хэрэглэж буй эко тэмдгүүд, түүний ач холбогдлын талаарх мэдлэг мэдээлэл олгох асрууд гарна. Мөн компаниуд үндэсний эко тэмдэг авахаар зорьж хийсэн ажлуудаа бүтээлч байдлаар танилцуулах, амталгаа болон бэлэг тараах хэлбэрээр тус тусын асарт үйл ажиллагаагаа явуулах юм.
- **“GreenerZ Parade”** – Байгальд ээлтэй үйлдвэрлэгчид, эко худалдан авалтын мэдлэгтэй хэрэглэгч хоёрыг нэгэн зорилгын дор нэгтгэх, таниулах ойлгуулах, олон нийтийн эко сонголтод нөлөөлөх, нэгдэхийг уриалах замаар арга хэмжээндээ татан оролцуулах, баяр ёслолын уур амьсгал оруулж, эерэг давлагаа үүсгэх жагсаал.

Тайзны Хөтөлбөр:

Цаг	Үйл ажиллагааны хөтөлбөр	Байршил
УДЭТ-н урд Ю.Цэдэнбалын цэцэрлэг		
11:00-11:10	Баярын нээлт - Хөтлөгч	Тайз
11:10-11:20	Нээлтийн үг • Европын Холбоо • Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам • Каритас Чех Републик ОУТББ	Тайз
11:20-11:30	• Өдөрлөгийн хөтөлбөр, үйл ажиллагааг танилцуулах - Хөтлөгч	Тайз
11:30-12:00	• GreenerZ парад – 300 орчим хүн оролцоно	Ю.Цэдэнбалын цэцэрлэг – Цирк
12:00-14:00	• Эко үйлдвэрлэгчдийн цаг /Бүтээлч байдлаар мэдлэг олгох, хэрэглэгчидтэй холбогдох, оролцоог бий болгох, хөгжөөх, урлагийн үзүүлбэрүүд зэргийг багтаасан байх /	Тайз
14:00-16:00	• Чөлөөт хэсэг – Асруудаар зочлох, асуулт хариулт бусад сонирхолтой арга хэмжээнүүдэд оролцох • DJ хөгжим • Green Therapy	Баярын талбай
16:00-16:30	• The Greenest Influencer – Арга хэмжээний тухай мэдээллийг өөрийн сувгаар хамгийн олон хүнд түгээсэн нөлөөлөгчийг шалгаруулж шагнал гардуулах • The Greenest Producer – Арга хэмжээнд хамгийн идэвхтэй, бүтээлч шинэлэг байдлаар оролцсон Үндэсний үйлдвэрлэгчдийг шалгаруулж шагнал гардуулах ёслол	Тайз
16:40-17:00	• Хаалтын арга хэмжээ – Үг хэлэх	Тайз

Төслийн талаарх ерөнхий мэдээлэл

Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах Үндэсний стратегитай нийцүүлэн хүнс, ус, ундааны салбарт нөөцийн хэмнэлттэй тойрог эдийн засагт шилжих, улмаар ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилгоор Пийпл Ин Нийд ОУТББ (People In Need), Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо, Хөгжлийн Шийдэл ТББ болон Каритас Чех Републик ОУТББ (Caritas Czech Republic) нар хамтран Улаанбаатар хот, Орхон, Сэлэнгэ аймгуудад “Эдийн Засгийн Ногоон Шилжилт” төслийг Европын Холбооны “СВИЧ-Эйшиа” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Каритас Чех Републик ОУБ | “Эдийн засгийн ногоон шилжилт” төсөл

Холбоо барих:

М.Солонго /Каритас Чех Републик ОУТББ/

solongo.munkhjargal@caritas.cz

+976 99299869

“Эдийн засгийн ногоон шилжилт” төсөл

2025.05.19